



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/0247

Булган сум

“Дэлхийн адууны өдөр” арга хэмжээнд
оролцох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 26 дугаар зарлиг, Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 79 дүгээр чуулганы 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн бүгд хуралдаанаар баталсан “Дэлхийн адууны өдөр” арга хэмжээнд оролцох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, уг арга хэмжээнд сумдаас оролцох морьтны тоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тус арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

3. “Дэлхийн адууны өдөр” арга хэмжээнд Булган аймгийн харьяат улс, аймаг, сумын алдарт уяачдыг бүрэн хамруулан оролцуулахыг аймгийн Морин спорт уяачдын холбооны тэргүүн (Б.Гүндсамбуу) болон сумын салбар холбооны дарга нарт, улс, аймаг, сумын аварга малчин, залуу аварга малчдыг хамруулан оролцуулах ажлыг зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан)-т, сум, аймгийн бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, оролцох бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангаж, удирдлага зохион байгуулалтаар хангахыг ажлын хэсгийн ахлагч (О.Ундрах)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР




Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дугаар сарын 07-ны/ний өдрийн
..... дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
- Гишүүд:
- Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга)
 - Б.Одхүү (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)
 - Б.Ариунболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
 - Г.Гантулга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Г.Давааням (Аймгийн Засаг даргын тамгын газрын Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга)
 - Э.Эрболд (Аймгийн засаг даргын тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба)
 - С.Батнасан (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)
 - Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга, хурандаа)
 - Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)
 - Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
 - Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
 - Г.Одсүрэн (Мал эмнэлгийн газрын дарга)
 - Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)
 - Г.Одончимэг (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
 - Б.Гүндсамбуу (Булган аймгийн Морин спорт уяачдын холбооны тэргүүн)
- Сумын Засаг дарга нар
Сумын Уяачдын холбооны тэргүүн нар
- Нарийн бичгийн дарга: Т.Нямхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа)

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дугаар сарын 07-ны/ний өдрийн
... дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



“Дэлхийн адууны баяр”-т сумдаас оролцох хуваарь

д/д	Сумын нэр	Сумаас оролцох унаач, адууны тоо	Тайлбар
1	2	3	4
1	Баян-Агт	25	
2	Баяннуур	30	
3	Бугат	25	
4	Булган	20	
5	Бүрэгхангай	30	
6	Гурванбулаг	25	
7	Дашинчилэн	30	
8	Могод	25	
9	Орхон	30	
10	Рашаант	30	
11	Сайхан	30	
12	Сэлэнгэ	20	
13	Тэшиг	20	
14	Хангал, Хялганат	25	
15	Хишиг-Өндөр	30	
16	Хутаг-Өндөр	20	
	Нийт	415	

--o00o--